



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 106

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Хулд сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 4,868,900.00 (дөрвөн сая найман зуун жаран найман мянга есөн зуу) төгрөгийн анхны өртөгтэй, 486,889.96 (дөрвөн зуун наян зургаан мянга найман зуун наян есөн төгрөг ерэн зургаан) мөнгөний хуримтлагдсан элэгдэл бүхий гүн өрөмдлөгийн цооногийг тус сумын Ерөнхий боловсролын сургуульд балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр: Хулд сумын Өмч хамгаалах зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Эрдэнэчимэгт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг сумын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 12 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР